

Есүсийн тухай түүхийг надад ярьж өгөөч

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын
Ахлагч Нийл Л.Андерсен

Есүс Христэд итгэх хувийн хүчтэй итгэл [хүүхдүүдийг тань] ирээдүйд зайлшгүй учрах сорилт бэрхшээлүүдэд бэлтгэнэ.

Хэрэв та ерөнхий чуулганы төгсгөлийн хуралдаан дээр үг хэлэх даалгавар авлаа гэхэд өөрийн чинь ээлж ирэхээс өмнө хэлэх үгийн тань ямар хэсгүүдийг бусад ах эгч нар хөндөн ярихыг мэдэхийн тулд тэдний үг бүрийг гээлгүй анхааралтай сонсож таарна. Сэдвийг хуваарилдаггүй, үг хэлэгчид аль нэг сэдэв дээр хамтран ажилладаггүй. Харин Их Эзэний арга зам ямагт хамгийн сайн нь байдаг нь мэдээж юм. Тэрээр үг хэлэгч бүрийн залбирлыг анхааралдаа авч, илчлэлт, эрх мэдэл, хүчээр дүүрэн сүнслэг симпони хөгжмийг тоглодог юм. Сэдвүүдийн давталт, нэг зарчим дээр суурилсан нөгөө зарчим, бошиглолын сэрэмжлүүлэг, санаа сэтгэлийг өргөсөн амлалтууд бурханлагаар байр байраа олон зохицолдсон байдаг нь юутай гайхамшиг билээ! Энэ чуулганаар бид Их Эзэний оюун ухаан, хүсэл тааллыг сонсож, мэдэрнэ гэдгийг би гэрчилж байна.

Ерөнхийлөгч Монсон өсвөр үеийнхнийг “үе үеийн хамгийн шилдэг”¹ нь хэмээн тодорхойлоод, залуучуудад хандан: “Гайхамшигтай цаг үед та нар энэ дэлхийд ирсэн билээ. Та нарын өмнө хязгааргүй их боломжууд байна”² гэж хэлжээ. Мөн ерөнхийлөгч, “Бид түгшүүртэй хүнд хэцүү цаг үед дэлхий дээр амьдарч байна”³. Энэ бол нийгмийн дийлэнх хэсэг нь Бурханы хуулиудыг дагалгүй зөрчих нь энгийн үзэгдэл болсон цаг үе юм.”⁴ Бидний анхаарлыг сарниулахаар бүтээгдсэн маш олон зүйлсээр бид хүрээлэгдээд байна. “Дайсан биднийг худал хуурмагийнхаа торонд урхидан оруулах боломж бүхнийг ашиглаж байна”⁵ гэж анхааруулсан билээ.

Бидний гарт өсвөр үеийнхэн маань байна. Тэд энэ дэлхийд чухал үүрэг хариуцлага, сүнслэг авъяас чадвартай ирсэн. Бид тэднийг бэлтгэн сургах ажилдаа тоомжиргүй хандаж болохгүй. Эцэг эх, багш нарын хуьд бидний өмнө тулгарах бэрхшээлүүд нь тэдний бодгальд сүнслэг гол цөмийг бий болгох явдал биш. Харин аль хэдийнэ мөнх бус байдлын өмнөх амьдралд ассан тэрхүү итгэлийн дөлийг ноцоох явдал юм.

Өнөө орой би Хүүхдийн Хэсгийн дуулал дахь хүүхдийн гуйлтад онцгой анхаарал хандуулахыг хүсч байна:

Есүсийн түүхийг яриач, би сонсох дуртай
Хэрэв Тэр энд байсан бол, Түүнээс асуух зүйлсийг надад хэлээч.6

Өнөөгийн дэлхийд хүүхэд бүр, залуу эмэгтэй, эрэгтэй бүр өөрсдөө үнэнд хөрвүүлэгдэх хэрэгтэй. Тэдний хүн нэг бүрт эцэг эх, залуучуудын удирдагчид болон дэмжигч найз нөхдөөсөө үл хамаарсан хувийн гэрэл, хувийн “хөдөлшгүй мөн гуйвшгүй”⁷ Есүс Христэд итгэх итгэл хэрэгтэй.

Есүсийн тухай түүх хүүхдүүдийн маань зүрхэн дэх итгэлийн цогийг ноцоон асаах сэвэлзэх салхи нь байж чадна. Есүс, “Би бол зам, үнэн, амь мөн”⁸ гэж хэлсэн билээ. Есүсийн тухай түүхүүдийг дахин дахин хуваалцах бүрт Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлийг авчирч, тэдний гэрчлэлийн суурийг хүчирхэг болгодог. Хүүхдүүддээ өгөх үүнээс илүү үнэтэй бэлгийг та нар мэдэх үү?

Есүс Христийн амьдрал ба сургаалууд хүүхдүүдийн маань бодол санаа, бодгальд суулгагдсан болов уу? Амьдралдаа юу хийхээ тэд бодох үедээ Аврагчийн амьдралын тухай боддог болов уу? Ирэх он жилүүдэд энэ нь юу юунаас илүү чухал байсаар байх болно.

Хүүхдүүд маань хамгаас агуу Есүс “Би энд байна. Намайг илгээгтүн”¹⁰ гэж тунхагласан мөнх бус амьдралд болсон зөвлөгөөнийг⁹ төсөөлөн боддог болов уу? Түүний үлгэр жишээг дагаж, үйлчлэх хүсэл өөрсдөд нь байгаа эсэхийг тэд харж чадаж байгаа болов уу?

Тэд Түүний даруухан төрөлтийн талаар¹¹ боддог болов уу? Дэлхийн Аврагчийг “тэжээлийн тэвшинд”¹² тавьсан байлаа. Түүний нөхцөл байдал материаллаг зүйлсийн талаар зөвөөр ойлгоход тэдэнд тусалдаг болов уу?

“Гуй, тэгвэл та нар хүлээн авна”¹³ гэж Есүс заасныг тэд мэддэг болов уу? Өөрсдийн асуудлуудтайгаа өвдөг сөгдөн суухдаа Түүний талархлын залбирлууд¹⁴, Эцэгтээ өргөсөн Түүний гуйлтууд¹⁵ хүүхдүүдийн маань оюун бодлоор дамжин гардаг болов уу?

Бид хүүхдүүдийн төлөөх Есүсийн хайрыг, өвөртөө тэднийг хэрхэн тэвэрснийг, тэдний төлөө хэрхэн залбирсныг, мөн хэрхэн гашуудан уйлсныг¹⁶ хэлсэн үү? Хүүхдүүд маань Есүс “[тэднийг] хүлээн авахаар”¹⁷ гараа дэлгэн зогсож байдгийг мэдэх үү”?

Бид тэдэнд мацгийн хуулийг заах үед тэд Есүсийн мацаг барилтын¹⁸ тухай түүхээс хүч чадлыг авдаг уу?

Өөрөө ганцаардах үед Өөрийн төлөөлөгчдөөс Тэрээр “Та нар бас явахыг хүсэж байна уу?”¹⁹ гэж асуухдаа, Аврагч ганцаардаж байсныг хүүхдүүд маань мэдэх үү”?

Аврагчийн гайхамшгийн хүчийг хүүхдүүд маань мэдэрсэн үү? Есүс уяман өвчтэй хүнийг²⁰ эдгээж, хараагүйг²¹ хараатай болгосон. Тэр 5000 хүнийг²² хооллож, далай тэнгисийг номхотгож²³, Лазарыг үхлээс²⁴ босгосон. Хүүхдүүд маань “гайхамшгууд итгэлээр үйлдэгддэг”²⁵ гэдэгт итгэж, өөрсдийн амьдралд гайхамшгийг авчрахын төлөө залбирч байна уу?

Хүүхдүүд маань синагогийн ахлагчид; “Бүү ай. Зөвхөн итгэ”²⁶ гэж хэлсэн Аврагчийн үгсээс урам зоригийг авч байна уу?

Бидний хүүхдүүд Түүний төгс амьдрал²⁷, Түүний Өөрийгөө умартсан үйлчлэл, Түүнээс урвасан хүмүүсийн урвалт, харгис хэрцгий Цовдлолтыг²⁸ мэдэх үү?

Түүний Амлалтын²⁹ үнэн бодит байдлыг, Тэрээр Америкт нифайчуудад зочилсныг³⁰, Ариун ойн цоорхойд³¹ Бошиглогч Иосеф Смит дээр Тэрээр хүрч ирснийг бид тэдэнд гэрчилсэн бил үү?

Бүгд зөв шударга болж, өвдөг бүр сөхрөн, Есүс бол Христ³² хэмээн хэл бүхэн хүлээн зөвшөөрөх Түүний сүр жавхлантай ирэлтийг тэд хүсэн хүлээдэг үү?

Бидний хүүхдүүд: “Есүсийн түүхийг яриач, би сонсох дуртай”³³ гэж хэлдэг бил үү?

Залуучууд, хүүхдүүд ээ: Чухал үүрэг хариуцлага болон агуу сүнслэг авъяас чадвартаа зохицохоор амьдар. Судруудыг нээж, Есүсийн тухай илүү ихийг мэдэхийг эрэлхийл. Иоханы номыг дахин уншиж, аав ээж, багш нартайгаа эсвэл өөр хоорондоо ярилцаад үзээрэй.

Аав ээж, эмээ өвөө нар хүүхэд, залуучуудыг хайрлан асрамжилдаг өөрийн хүүхэдгүй хүмүүст Есүс Христийн тухай бүр олон дахин ярьж бай гэж би зөвлөе. Түүний ариун нэрэнд агуу сүнслэг хүч байдаг. “Түүгээр хүмүүний үрсэд аврал ирж чадах тэр нэгээхэн ч өөр нэр өгөгдөхгүй, басхүү нэгээхэн ч арга үгүй бөгөөд зөвхөн Төгс Хүчит Их Эзэн, Христийн нэрээр мөн энэ нэр дээр буюу.”³⁴

Өнөөдөр орон гэртээ эцэггүй ганцаараа хүүхдүүдээ өсгөн бойжуулж байгаа олон эх байна. Та нар Есүс Христийн тухай ярих үед тэнгэрийн хүч та нарыг адислаж буйг мэдрэх болно гэдгийг би амлаж байна.

Нөхөр нь нас барсны дараа Стелла Өүкс эгч гурван хүүхдээ (түүний дотор Ахлагч Даллин Х.Өүксийг³⁵) ганц бие эхийн хувьд өсгөн бойжуулсан юм. Тэр нэг удаа, “Өөрийн хайр болон мөн би эх хүний хувьд хүлээсэн үүргээ биелүүлж чадах болно гэдгийг надад мэдүүлсэн юм. Би яг л хайраар хүрээлүүлсэн мэт болж, гарч ирэх сөрөг зүйлсийг даван гарахад Тэр [бидэнд туслан дэмжих болно] гэдгийг [мэдсэн]”³⁶ гэж ярьсан юм.

Би аав нарт хандан онцгой хүсэлт тавъя: Хүүхдүүдтэйгээ Аврагчийн тухай чухал ач холбогдолтой сэдвээр ярилц. Тэдэнд ээж нарынх нь туршлагуудаас гадна та нарын итгэлийн баталгаа өгөх үзэл бодол, үг хэллэг хэрэгтэй.

Хүүхдүүд маань итгэлтэй зүрх сэтгэлээр сонсохгүй цаг үеүд байх боловч Есүсийн тухай та нарын гэрчлэл тэдний бодол санаа, бодгальд нь үлдэх болно. Та нар буруу замыг сонгосон Алмагийн тухай түүхийг санаж байна уу? Эргэж ирэхдээ тэрээр:

“Манай аав Есүс Христийн ирэлт, дэлхийн нүглүүдийг цагаатгах тухай [ярьж байсныг] би санасан гэж хэлсэн байдаг.

“Эдүгээ, миний оюун энэ бодол дээр тогтож тунгаах зуур, би зүрх сэтгэлдээ хашгирч: Ай Есүс, Бурханы Хүү та, намайг нигүүлсээч”³⁷ гэжээ.

Хэрэв хүүхэд сонсохгүй байвал бүү цөхөр. Үнэн ба цаг хугацаа та нарын талд байгаа. Цаг нь болоход та нарын үгс тэнгэрээс буух мэт тэдний санаанд буух болно. Та нарын гэрчлэл хүүхдүүдийг чинь хэзээ ч орхихгүй.

Та нар Аврагчийн тухай хүндэтгэлтэйгээр машин дотроо, автобусанд, оройн хоолны ширээний ард, залбиралд сөхрөн суусан үед, судруудаас суралцах үед, эсвэл үдшийн ярианд тань Их Эзэний Сүнс та нарын үгсийг батлах болно³⁸.

Та нар өөрсдөөсөө шалтгаалах бүхнээ хийхэд Есүсийн тухай гэрчлэл алгуурхнаар, аажим аажмаар хүүхдүүдийн чинь зүрх сэтгэлд буух болно. Тэнгэрлэг Эцэгтээ хандсан даруухан залбиралд тэд ирж, Ариун Сүнсээр дамжуулан Түүний нөлөөг мэдрэх болно. Есүс Христэд итгэх баттай бөгөөд хүчтэй хувийн итгэл нь гарцаагүй тулгарах бэрхшээлүүдэд тэднийг бэлтгэдэг.³⁹

Би БЯИС-ийн оюутан байхдаа, Билл Форрест, Дебби Хатчинз нартай танилцаж билээ. Билл номлолоосоо буцаж ирээд байсан юм. Билл, Дебби хоёр бие биендээ дурлаж, Оакландын Калифорнийн Ариун Сүмд гэрлэв. Тэд Аризонагийн Месад орон гэртэй болж, таван хүү, хоёр охиноор адислагдсан. Билл, Дебби хоёр өөрсдөө Их Эзэн Есүс Христийг хэрхэн хайрласны адил Түүнийг хайрлах хэрэгтэйг хүүхдүүддээ зааж сургасан. Одоо Мексикийн Оаксака Номлолд үйлчилж байгаа тэдний хүү Ахлагч Даниел Форрест, “Бид өглөө бүр ямар ч асуудалгүйгээр хичээл давтах ширээний ард судруудын талаар хэлэлцэн сууж байдаг байлаа” гэж ярьж байна.

Тэдний охин Кара гэрлэж, хоёр хүүхэдтэй болсон ч өглөө бүр аав нь ахлах сургуульд түүнийг хүргэж өгдөг байсныг тод санадаг аж. Кара хэлэхдээ, “Аав маань хүмүүсийн хэлсэн үгс, судрууд болон шүлэг цээжлэх дуртай байсан. Тэгээд [өглөө эрт намайг хүргэж өгөх замдаа] бид тэдгээрийг давтдаг байлаа. Түүний дуртай судруудын нэг нь “... Санагтун, санагтун, Бурханы Хүү, Христ болох, бидний Гэтэлгэгчийн хадан дээр та нар сууриа тавих ёстойг санагтун, иймээс чөтгөр хүчит салхиа ... та нар дээр нүдэхэд, ... [тэр] [та нарыг] доош чирж дийлэх хүчгүй байх болно, ... унах аргагүй суурь болох хадны учир болой”⁴⁰ гэж хэлсэн юм.

Яг 10 жилийн өмнө, 2000 оны Христийн амилалтын баярын ням гарагийн өмнөх баасан гарагт Билл Форрест Аризонагийн Истэйт Гровз тойргийн бишопоор үйлчилж байсан юм. Ажилдаа явж байх замдаа гэрээс нь 1.6 километрийн зайтай түүний машиныг хайрга зөөдөг ачааны машин мөргөж, тэрээр осолд орсон юм. Биллийг эмгэнэлт осолд орсны дараа удалгүй гэрээсээ гарсан Дебби болон хүүхдүүд нь санаангүй золгүй явдлын газар дээр иржээ. Билл ослоос амьд үлдэж чадсангүй. Хайрт нөхөр мөн аавынх нь мөнхийн сүнс үхлийг ялж, Амилалтын аугаа сүр хүч болсон Бурханы Хүү, Түүний гэрт гэнэт хүргэгдэн, тэд хамтдаа Христийн амилалтын баярын ням гарагийг тэмдэглэсэн биз ээ.

Дебби болон түүний долоон хүүхэд (бага нь дөнгөж таван настай) тэдэнд хэрэгтэй хүч тэнхээг яаж олсон бэ? Аавыгаа осолд орох үед 15 настай байсан Кара саяхан надад, “Би [ээж аав хоёртоо] [Аврагчийн тухай] заадаг байсан арга замуудын төлөө талархалтай байдаг. Тэд надтай хамт судруудыг нээж, надтай хамт залбирч, [Аврагчийн] нигүүлсэл, энэрэл, хайр тэвчээртэй байдлын үлгэр жишээ байсан. Христийн амилалтын баяр [нь] жил бүр миний хувьд Аврагчийнхаа амьдрал,

Түүний үүрэг зорилго болон Амилалтыг эргэн дурсах онцгой цаг мөч бөгөөд газар дэлхий дээрх эцгийн минь тухай мөн санагдуулдаг билээ” гэж ярих.

Ахлагч Даниел Форрест, “аавыгаа нас барахад би 10 настай байсан. Маш хэцүү үе. Ээж минь үргэлж Аврагчийн сургаалын үлгэр жишээ байсан. Надад аавын маань Испанид номлол хийж байхдаа зүүж байсан нэрийн тэмдэг нь байдаг. Аавын минь хэлсэн миний дуртай [хоёр] эшлэлийн ‘Нэг нь Их Эзэн байгаа цагт хоёр хүн бүгдийг хийж чадна,’ нөгөө нь ‘Аврагч бидний суурь байх ёстой. Үүнгүйгээр бид бүдчих болно’ гэсэн эшлэл юм гэж билээ.”

Есүс Христэд итгэх итгэл Форрестын хүүхдүүдийн зүрх сэтгэлийг дүүргэжээ. Энэ Христийн амилалтын баярын амралтын өдрүүдэд, тэдний аав нас бараад 10 жил өнгөрсний дараа, тэд түүнийг маш ихээр санасан ч түүний “үхлийн гашуун нь Христээр залгигдсан юм.”⁴¹ Тоолж баршгүй Аврагчийн бэлэг байгаа учраас өөрсдийн дэлхийн эцэг болон, Тэнгэрлэг Эцэгтэйгээ дахин хамт байх болно гэдгийг тэд мэднэ.

Есүсийн түүхийг яриач.

Бид тун удахгүй Бурханы бошиглогчийн үгийг сонсох болно. Их Эзэн бошиглогчийнхоо талаар: “Түүний үгийг та нар миний амнаас гарсан мэтээр хүлээн авах ёстой”⁴² хэмээн хэлсэн байдаг. Ерөнхийлөгч Томас С.Монсон бол дэлхий дээрх Их Эзэний ам гэдгийг би гэрчилж байна.

Есүс бол Христ бөгөөд бүх хүн төрөлхтний Аврагч гэдгийг сана. Түүний амьдрал, Түүний цагаатгал, Түүний амилалт, Түүний ирэлтийг хүлээх нь нар мандахыг хүлээхтэй адил гарцаагүй үнэн гэдгийг би гэрчилж байна. Түүний нэр үүрд мөнхөд, үеийн үед алдаршиг⁴³, Есүс Христийн ариун нэрээр, амен.

ЭШЛЭЛ

1. Томас С.Монсон, “Constant Truths for Changing Times,” *Лиахона*, 2005 оны 5-р сар, 19.
2. Томас С.Монсон, “May You Have Courage,” *Лиахона*, 2009 оны 5-р сар, 123.
3. Томас С.Монсон, “Examples of Righteousness,” *Лиахона*, 2008 оны 5-р сар, 65.
4. Томас С.Монсон, “Хаалтын үг,” *Лиахона*, 2009 оны 11-р сар, 109.
5. Томас С.Монсон, “Until We Meet Again,” *Лиахона*, 2009 оны 5-р сар, 113.
6. “Есүсийн тухай түүхүүдийг надад ярьж өгөөч,” *Children’s Songbook*, 57.
7. Алма 1:25.
8. Иохан 14:6.

9. Абрахам 3:2:28-ыг үз.
10. Абрахам 3:27
11. Лук 2:7-г үз.
12. Лук 2:7-г үз.
13. 3 Нифай 27:29.
14. Лук 10:21-ийг үз.
15. Лук 11:2-4-ийг үз.
- 16.3 Нифай 17:11-24-ийг үз.
17. Мормон -6:17-г үз.
18. Лук 4:1-13-ыг үз.
19. Иохан 6:67. Ерөнхийлөгч Монсон өнгөрсөн жил залуучуудад хандаж үг хэлэхдээ: Итгэдэг зүйлсээ хамгаалахад. . . би та нарыг уриалан дуудаж байна. Итгэлийн тань үндэс бат бөх байхгүй бол та нарын итгэлийг соригчдын доог тохууг тэсэн гарах нь та нарт хэцүү байх болно” гэжээ (*Лиэхона, 2009 оны 5-р сар, 126*).
20. Марк 1:40-42-ыг үз.
21. Лук 18:35-43-ыг үз.
22. Марк 6:34-44-ийг үз.
23. Марк 4:35-41-ийг үз.
24. Иохан 11:8-53-ыг үз.
25. Моронай 7:37.
26. Марк 5:36.
27. 1 Петр 2:21-25-ыг үз.
28. Лук 22:47-48; 23:32-46-г үз.
29. Иохан 20:11-23-ыг үз.
30. 3 нифай 11-26-г үз.
31. Иосеф Смит-Түүх 1:17-г үз.

32. Сургаал ба Гэрээ 88:104-ийг үз.

33. “Tell Me the Stories of Jesus”

34. Мозая 3:17.

35. Ахлагч Даллин Х.Өүкс нэг удаа: “Би бага байхдаа орой бүр цагийнхаа ихэнхийг ном уншиж өнгөрөөдөг байлаа. Миний дуртай номуудын нэг нь Библийн [168] түүхтэй. . . *Hurlbut’s Story of the Bible* гэдэг ном байв. Би эдгээр түүхүүдэд нэн их дуртай, олон дахин уншдаг байж билээ” гэж бичжээ (Bible Stories and Personal Protection,” *Ensign*, 1992 оны 11-р сар, 37).

36. Стелла Өүкс, “Thy Will Be Done,” in Leon R. Hartshorn, comp., *Remarkable Stories from the Lives of Latter-day Saint Women*, боть 2, (1973-75), 2:184.

37. Алма 36:17-18.

38. “Мөнх амьдралын талаар эцгийнхээ ярьж байхыг олонтаа сонссон тэр үгс. . . зүрх сэтгэлд минь гүнзгий шингэсэн байв. Мөн бодгаль минь өлссөн байв; мөн намайг Бий Боллогчийн өмнө сөхөрсөн би” (Инос 1:3-4) хэмээн аавынхаа талаар Иносын хэлсэн үгс манай хүүхдүүдээс бидний талаар хэлэх үгс байх нь өнөөгийн дэлхийд бидэнд бүр ч хэрэгтэй байна.

39. “Сайн мэдээний тухай, Аврагчийн тухай, бидний Тэнгэрлэг Эцэгийн тухай гэрчлэл тань бат бөх үндэс суурьтай байвал, энэ нь насан туршдаа хийх зүйлд чинь нөлөөлөх болно. . . . Байнга тэжээн тэтгэвэл гэрчлэл тань та нарыг аюулгүй авч явах болно” гэж Ерөнхийлөгч Монсон залуучуудад амлажээ (*Лиакхона*, 2009 оны 5-р сар, 126).

40. Хиламан 5:12.

41. Мозая 16:18.

42. Сургаал ба Гэрээ 21:5.

43. Алма 26:12-ыг үз.